

## **ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ** **/Шинэчилсэн найруулга/**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### ***1 дүгээр зүйл. Хуулийн зорилт***

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, Монгол Улсын агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй байдлыг хангах, агаарын навигацийн үйлчилгээ, аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

#### ***2 дугаар зүйл. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж***

2.1. Иргэний нисэхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### ***3 дугаар зүйл. Иргэний нисэхийн үйл ажиллагааны үндсэн зарчим***

3.1. Иргэний нисэхийн үйл ажиллагаа нь аюулгүй, үр ашигтай, хүртээмжтэй байх зарчмыг баримтлана.

#### ***4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ***

4.1. Энэ хуулиар дараахь харилцааг зохицуулна:

4.1.1. Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаа;

4.1.2. Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа болон нутаг дэвсгэрт байрлаж байгаа иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа;

4.1.3. Тухайн улсын хуульд өөрөөр заагаагүй бол, гадаад улсын нутаг дэвсгэрт байрлаж байгаа, эсхүл тухайн улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа Монгол Улсын иргэний агаарын хөлгийн үйл ажиллагаа.

4.2. Энэ хууль нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж байгаа улсын агаарын хөлгийн байлдааны үүргийн нислэгээс бусад нислэгийн хөдөлгөөнийг зохицуулна.

4.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт онц болон дайны байдал зарласан үед иргэний нисэхийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

#### ***5 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт***

5.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно;

- 5.1.1. “агаарын хөлөг” гэж агаарын өгсөх урсгалын нөлөөллөөр бус, өөрөө агаартай харилцан үйлчилсний хүчинд агаарт тогтож, хөдөлгөөн хийж чадахаар бүтээгдсэн аливаа төхөөрөмжийг;
- 5.1.2. “агаарын хөлгийн дарга” гэж тухайн агаарын хөлгийн удирдлагыг гүйцэтгэж, нислэгийн аюулгүй байдлыг биечлэн хариуцахаар томилогдсон нисгэгчийг;
- 5.1.3. “агаарын зам” гэж агаарын хөлгийн нислэгийг аюулгүйгээр гүйцэтгэхэд зориулсан өндөр ба өргөнөөр хязгаарлагдсан агаарын зайг;
- 5.1.4. “агаараас гүйцэтгэх ажил” гэж агаарын хөлөг ашиглан ургамал, билчээр хамгаалах, барилга байгууламжийн угсралт, газар зүйн зураглалын ажил гүйцэтгэх, тандалт судалгаа хийх, эргүүл, эрэн хайх зэрэг тусгайлсан ажил үйлчилгээг;
- 5.1.5. “агаарын навигацийн үйлчилгээ” гэж нислэгийн бүх үе шатанд үзүүлэх нислэгийн хөдөлгөөний удирдлагын, холбоо, навигаци, ажиглалтын, нисэхийн мэдээллийн, нисэхийн цаг уурын болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах цогц үйл ажиллагааг;
- 5.1.6. “агаарын навигацийн байгууламж” гэж агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөн болон буулт, хөөрөлтийг удирдан чиглүүлэхэд зориулагдсан тоног төхөөрөмж, барилга байгууламжийн цогцолборыг;
- 5.1.7. “агаарын тээвэрлэгч” гэж иргэний нисэхийн холбогдох дүрмийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийг;
- 5.1.8. “агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ” гэж арилжааны агаарын тээврийн болон тусгай зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон баримт бичгийг;
- 5.1.9. “агаарын хөлгийн осол, тохиолдол” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 13-тодорхойлсныг;
- 5.1.10. “агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба” гэж агаарын хөлгийн осол, тохиолдлыг Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын дагуу шинжлэн шалгах эрх бүхий байгууллагыг;
- 5.1.11. “аэродром” гэж агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон гадаргуу дээрх хөдөлгөөнд ашиглахад зориулан сонгосон газар, эсхүл усан дээр байгуулсан талбай болон байгууламжийг;
- 5.1.12. “аэродром орчмын аюулгүйн бүс” гэж аэродромыг байгуулахдаа нислэгийн аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагыг үндэслэн тогтоосон аэродром орчмын газар, эсхүл усан гадаргуу, агаарын орон зайг;
- 5.1.13. “аюулгүй байдлын зөвлөмж” гэж шинжлэн шалгах ажиллагааны үр дүнд, эсхүл аюулгүй байдлын талаар гаргасан судалгаа, төрөл бүрийн эх үүсвэрээс үндэслэн агаарын хөлгийн осол, хэрэг явдлаас сэргийлэх зорилгоор Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанаас гаргасан баримт бичгийг;

- 5.1.14. “аюулгүй байдлын өгөгдөл” гэж аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор иргэний нисэхийн бүх талын эх үүсвэрээс цуглуулсан аюулгүй байдлын мэдээлэл болон нотлох баримтын иж бүрдлийг;
- 5.1.15. “аюулгүй байдлын мэдээлэл” гэж аюулгүй байдлын өгөгдлийг боловсруулах, ангилах болон дүн шинжилгээ хийх замаар аюулгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэхэд ашиглагдах мэдээллийг;
- 5.1.16. “аюултай бараа” гэж агаараар тээвэрлэхэд өөрийн шинж чанараараа хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин болон нислэгийн аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, техникийн зааварчилгаанд заасан биет зүйл болон бодисыг;
- 5.1.17. “аюул тулгарсан агаарын хөлөг” гэж агаарын хөлөг, зорчигч болон хөлгийн багийнханд аюултай байж болзошгүй, эсхүл яаралтай тусламж шаардлагатай нөхцөл байдалд орсон агаарын хөлгийг;
- 5.1.18. “нисэхийн аюулгүйн хамгаалалт” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 17-д тодорхойлсны дагуу иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдэл болон халдлагаас хамгаалахтай холбогдсон цогц арга хэмжээг;
- 5.1.19. “багийн гишүүн” гэж нислэгийн үед агаарын хөлөгт үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтныг;
- 5.1.20. “бүртгэгч улс” гэж агаарын хөлгийг бүртгэсэн улсыг;
- 5.1.21. “зорчигч” гэж дараахь этгээдийг:
- 1/ арилжааны нислэгийн хувьд тээвэрлэлтийн гэрээний дагуу агаарын хөлөгт зорчиж байгаа этгээдийг;
  - 2/ арилжааны бус нислэгийн хувьд агаарын хөлөгт зорчиж байгаа, багийн гишүүдээс бусад этгээдийг;
- 5.1.22. “Иргэний агаарын хөлөг” гэж улсын агаарын хөлгөөс бусад бүх төрлийн агаарын хөлөг;
- 5.1.23. “Иргэний нисэх” гэж иргэний агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж байгааг;
- 5.1.24. “иргэний нисэхийн дүрэм” гэж иргэний нисэхийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Чикагогийн конвенцийн Хавсралтуудын суурь түвшинд нийцүүлэн боловсруулж, баталсан эрх зүйн баримт бичгийг;
- 5.1.25. “маягийн гэрчилгээ” гэж агаарын хөлгийн хийц нь нислэгт тэнцэх чадварын холбогдох шаардлагад нийцэж байгааг Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгууллагаас тодорхойлж олгосон баримт бичгийг;
- 5.1.26. “нислэгийн ажилтан” гэж нислэгийн үйл ажиллагаанд оролцож буй:
- 1/ нисэх багийн гишүүд, агаарын хөлгийн техник үйлчилгээний болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын ажилтнууд;
  - 2/ агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнс болон түүний бүрдэл хэсгийн техникийн засвар үйлчилгээ, нисэхийн цахилгаан, холбоо навигацйн ажилтан;

3/ нислэгийн мэдээллийн болон зохицуулалтын ажилтан;

- 5.1.27. “нислэгийн аюулгүй байдал” гэж иргэний нисэхийн үйл ажиллагааг хүний амь нас, эрүүл мэнд болон бусдын эд хөрөнгөд хохирол учруулах эрсдэлгүй гүйцэтгэх нөхцөл болон чадварыг;
- 5.1.29. “нисэх баг” гэж нислэгийн хугацаанд агаарын хөлгийн аюулгүй ажиллагааг хангах хариуцлага хүлээсэн, хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэхтэй агаарын хөлгийн багийн гишүүдийг;
- 5.1.30. “нислэг үйлдэх агаарын зай” гэж агаарын хөлгийн хөөрч, буух аюулгүй байдлыг хангасан болон нислэгийн аюулгүй бага өндрөөс дээшхи агаарын орон зайг;
- 5.1.31. “нислэгийн оператор” */нислэг эрхлэгч/* гэж агаарын тээвэрлэгчээс бусад нислэгийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ эзэмшигчийг;
- 5.1.32. “нислэг” гэж дараахь үйл явцыг:
- 1/ нислэгийн үйл ажиллагааны хувьд агаарын хөлөг нислэг үйлдэх зорилгоор хөдлөхөөс эхлэн газардаж, хөдөлгөөнөө бүрэн зогсоох хүртэлх;
  - 2/ агаарын тээвэрлэгчийн хариуцлагын хүрээг тодорхойлох зорилгын хувьд тээвэрлэлтийн гэрээ байгуулсан зорчигч агаарын хөлөгт сууснаас эхлэн агаарын хөлгийн бүхээгээс гарах хүртэлх;
- “нисэх клуб” нислэгийн хамтлаг, нислэгийн алба, нисэх төхөөрөмжийн хамтлаг
- “дрон” зайнаас удирдах хүнгүй нисэх төхөөрөмжийг;
- 5.1.33. “нисэх буудал” гэж иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн аэродром, агаарын тээврийн үйлчилгээний барилга байгууламж бүхий цогцолборыг;
- 5.1.34. “нислэгт тэнцэх чадвар” гэж агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнс, бүрдэл хэсэг нь нислэгийн аюулгүй байдлын шаардлагад нийцэж байгаа нөхцөл байдлыг;
- 5.1.35. “олон улсын нислэг” гэж хоёр болон түүнээс дээш улсын агаарын зайд үйлдэх нислэгийг;
- 5.1.36. “орох, гарах цэг” гэж улсын хилийг агаарын замаар нэвтрэх газар зүйн байршлыг;
- 5.1.37. “тусгай зориулалтын нислэг” гэж агаарын хөлгөөр хөдөө аж ахуйн, барилгын ажил гүйцэтгэх, зураг авах, судалгаа, ажиглалт, эргүүл хийх, эрэн хайх, авран туслах нислэг, зар сурталчилгаа хийх болон бусад ажил үйлчилгээг;
- 5.1.38. “улсын агаарын хөлөг” гэж цэрэг, цагдаа, хил хамгаалах, гаалийн болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын агаар хөлгийг;
- 5.1.39. “Чикагогийн конвенци” гэж Монгол Улс 1989 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Чикаго хотноо батлагдсан олон улсын конвенци болон түүний Хавсралтуудыг;

5.1.40. “шинжлэн шалгах” гэж осол, тохиолдлоос сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, нөлөөлсөн хүчин зүйл бүрийг тогтоож, дүгнэлт гарган, аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргах үйл ажиллагааг;

5.1.41. “шинжлэн шалгах багийн ахлагч” гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 13-ын дагуу шинжлэн шалгах ажиллагааг удирдах, хянах, гүйцэтгэхээр томилогдсон, мэргэшсэн шинжлэн шалгагчийг;

5.1.42. “эдийн засгийн зохицуулалтын дүрэм” гэж иргэний нисэхийн үйл ажиллагаанд эдийн засгийн зохицуулалт хийх зорилгоор олон улсын стандарт, зөвлөмжид нийцүүлэн боловсруулж, баталсан эрх зүйн баримт бичгийг.

5.2 Иргэний нисэхийн үйл ажиллагаанд хэрэглэдэг бусад нэр томъёог иргэний нисэхийн дүрэм, нэр томъёоны стандартад зааснаар ойлгоно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ.**

### **ИРГЭНИЙ НИСЭХИЙГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ**

#### **6 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1. Улсын Их Хурал иргэний нисэхийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.1.1. иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэнд нь хяналт тавих;

6.1.2. иргэний нисэхийн асуудлаарх олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн орох, гарах асуудлыг шийдвэрлэх;

6.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

#### **7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

7.1. Засгийн газар иргэний нисэхийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцид заасан онц бүрэн эрхийг Монгол Улсын агаарын зайд хэрэгжүүлэх;

7.1.2. иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

7.1.3. иргэний нисэхийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.4. Засгийн газар хоорондын агаарын харилцааны болон бусад хэлэлцээрийг батлах;

7.1.5. иргэний нисэхийн үндэсний хөтөлбөрүүдийг батлах;

7.1.6. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор, Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга буюу Улсын ерөнхий байцаагчийг томилох, чөлөөлөх;

- 7.1.7. орон нутгийн агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээнд татаас олгох асуудлыг шийдвэрлэх;
- 7.1.8. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн олон улсын нисэх буудал байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэх;
- 7.1.8. хуульд заасан бусад бүрэн эрх.

**8 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний-бүрэн эрх**

8.1. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь иргэний нисэхийн салбарын үйл ажиллагааг Засгийн газрын бодлогын хүрээнд хянаж, удирдан чиглүүлэх үүрэг хүлээж, дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 8.1.1. иргэний нисэхийн салбарын хөгжлийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- 8.1.2. Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд нийтийн эрх ашигт нийцүүлэн нислэгийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын хэрэгжилтийг хангуулах;
- 8.1.3. агаарын навигаци, нисэх буудал, нисэхийн аюулгүйн хамгаалалт болон агаарын тээврийн бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- 8.1.4. иргэний нисэхийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн хүрээнд нислэгийн аюулгүй байдлыг хангах, нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах үйл ажиллагаанд зориулан захиран зарцуулах;
- 8.1.5. Засгийн газар хоорондын агаарын харилцааны болон бусад хэлэлцээрийг байгуулах;
- 8.1.6. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах;
- 8.1.7. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны Дарга бөгөөд Ерөнхий шинжлэн шалгагчийг томилох, чөлөөлөх;
- 8.1.8. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, үйл ажиллагааны дүрмийг батлах;
- 8.1.9. Агаарын хөлгийн осол, тохиолдлыг шинжлэн шалгах ажиллагааны дүрмийг батлах;
- 8.1.10. шаардлагатай гэж үзвэл агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагааг Хэлэлцэн тохирогч улсын шинжлэн шалгах байгууллагатай хамтран гүйцэтгэх, эсхүл тухайн байгууллагад хэсэгчлэн, эсхүл бүрэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх;
- 8.1.11. энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан иргэний нисэхийн дүрмийг батлах;
- 8.1.12. энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан эдийн засгийн зохицуулалтын дүрмийг батлах;

- 8.1.13. нислэгийн зах зээлд нэвтрэх эдийн засгийн зохицуулалтын зөвшөөрөл олгох;
- 8.1.14. олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчийг томилох, нислэгийн шугамыг хуваарилах;
- 8.1.15. иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын зайд орох, гарах цэг, агаарын замыг тогтоох;
- 8.1.16. өмчийн хэлбэрээс үл хамаарч нийтийн хэрэглээний нисэх буудал, аэродромын төлөвлөлт, ашиглалтын бодлогыг хэрэгжүүлэх;
- 8.1.17. иргэний нисэхийн хяналт, эдийн засгийн зохицуулалт болон агаарын хөлгийн осол, тохиолдлыг шинжлэн шалгах ажиллагааг энэ хуулийн 9.3-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх;
- 8.1.18. иргэний нисэхийн салбарын ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогийг харгалзан нэмэгдэл цалин хөлс, тэтгэмж олгох, нийгмийн баталгааг хангахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх;
- 8.1.19. шинжлэн шалгагч, иргэний нисэхийн хяналтын байцаагч, ажилтны дундаж цалингийн хэмжээ нь салбарын хувийн хэвшилд ажиллагчдын адилтгах мэргэжлийн ажилтны цалингийн дунджаас 5.0 буюу түүнээс дээш хувиар бага болсон тохиолдолд албан тушаалын цалингийн хэмжээг нэмэгдүүлэх талаар холбогдох төрийн байгууллагаас ирүүлсэн саналыг судлах, шийдвэрлэх;
- 8.1.20. хуульд заасан бусад.

8.2. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 8.1.2-т заасан бүрэн эрхийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлэн гүйцэтгүүлж болно.

8.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 8.2-т заасны дагуу бүрэн эрхээ шилжүүлсэн нь түүнийг нислэгийн аюулгүй байдлын талаар хүлээх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

### ***9 дүгээр зүйл. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрхлэх нийтлэг асуудал, түүний санхүүжилт***

9.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.

9.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.2.1. нислэгийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын чиглэлээр:

- 9.2.1.1. нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээжүүлэлт;
- 9.2.1.2. агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хяналт, гэрчилгээжүүлэлт;
- 9.2.1.3. нислэгийн үйл ажиллагааны хяналт, гэрчилгээжүүлэлт;
- 9.2.1.4. агаарын хөлгийн бүртгэл.

9.2.2. иргэний нисэхийн үйлчилгээний хяналт, зохицуулалтын чиглэлээр:

9.2.2.1. агаарын навигацийн үйлчилгээний хяналт, гэрчилгээжүүлэлт;

9.2.2.2. аэродромын хяналт, гэрчилгээжүүлэлт;

9.2.2.3. нисэхийн аюулгүйн хамгаалалтын хяналт, гэрчилгээжүүлэлт.

9.2.3. Иргэний нисэхийн дүрэм болон бусад эрх зүйн акт боловсруулах;

9.2.4. иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын асуудлаар олон улсын иргэний нисэхийн байгууллагуудтай хамтран ажиллах;

9.2.5. үнэмлэх, гэрчилгээ олгохтой холбоотой шалгалт авах, үзлэг хийх ажлын үнэлгээг тогтоох;

9.2.6. аэродром орчмын аюулгүйн бүсийг тогтоох асуудлыг нутгийн захиргааны байгууллагатай хамтран шийдвэрлэх;

9.2.7. иргэний нисэхийн салбарт холбогдох мэдээлэл цуглуулах, бэлтгэх, солилцох, түгээх, түүнчлэн энэ талаар бусад этгээдтэй хамтран ажиллах;

9.2.8. хуульд заасан бусад бүрэн эрх.

9.3. Энэ хуулийн 9.2-т заасан болон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

9.3.1. үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалтын хураамж;

9.3.2. иргэний нисэхийн үйлчилгээний хяналт, зохицуулалтын ногдол;

9.3.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт буулгүйгээр дамжин өнгөрөх нислэгт үзүүлсэн агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогын найм хүртэлх хувь;

9.3.4. нислэгийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтын ногдол - Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэгт нийлүүлэгдэж байгаа турбинт хөдөлгүүрийн түлшний үнийн дүнгийн хоёр хувь;

9.3.5. төрийн болон бусад санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр;

9.3.6. өөрийн үзүүлсэн зөвлөх үйлчилгээний болон сургалтын орлого;

9.3.7. байгууллагын оюуны өмчийн эрхэд хамаарах бусад орлого.

9.4. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн хяналтын байцаагчийг энэ хуулиар олгогдсон хяналтын чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хувцас, хэрэгслээр хангана.

**10 дугаар зүйл. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад тавих шаардлага**

10.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга Төрийн албаны тухай, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна дараахь шаардлагыг хангасан байна:



10.1.1. нислэгийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан байх;

10.1.2. иргэний нисэхийн салбарт 15-аас доошгүй жил, үүнээс удирдах албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай, мэргэжлийн болон ёс зүйн шаардлага хангасан;

10.1.3. олон улсын иргэний нисэхийн байгууллагын албан ёсны хэрэглээнд ашигладаг аль нэг гадаад хэлний мэдлэгтэй.

### ***11 дүгээр зүйл. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын бүрэн эрх***

11.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга бөгөөд Ерөнхий байцаагч нь нислэгийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах зорилгоор иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын чиглэлээр дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 11.1.1. иргэний нисэхийн дүрмийн хэрэгжилтийг хангуулахад шаардлагатай удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах;
- 11.1.2. техник, технологийн заавар, журмыг батлах;
- 11.1.3. иргэний нисэхийн дүрэмд заасан үнэмлэх, гэрчилгээ олгох;
- 11.1.4. Хэлэлцэн тохирогч бусад улстай нислэгийн аюулгүй байдлын хяналтын үүрэг, хариуцлага хуваалцах гэрээ байгуулах;
- 11.1.5. аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн осол, тохиолдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- 11.1.6. онцгой нөхцөл үүссэн үед нислэгийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор нэн даруй хэрэгжүүлэх аюулгүй байдлын тушаал гаргаж нийтэд яаралтай мэдээлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
- 11.1.7. энэ хуулийн 9.3-т заасан санхүүжилтийг эрхлэн шийдвэрлэх;
- 11.1.8. иргэний нисэхийн дүрэмд заасан үнэмлэх, гэрчилгээ эзэмшигчид үзлэг шалгалт хийх;
- 11.1.9. нислэгт тэнцэх чадвараа алдсан агаарын хөлгийн нислэгийг зогсоох, гэрчилгээг хураан авах;
- 11.1.10. тухайн нислэг нь зорчигч болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй тохиолдолд нислэгийг зогсоох хүртэл арга хэмжээг авах;
- 11.1.11. нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа ажилтан мэргэшил болон эрүүл мэндийн хувьд нислэгт бэлэн биш байгаа нь үзлэг шалгалтаар тогтоогдсон бол тухайн ажилтныг нислэгийн үйл ажиллагаанд оролцуулахгүй байх;
- 11.1.12. иргэний нисэхийн хууль тогтоомж зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- 11.1.13. хуульд заасан бусад.

### ***12 дугаар зүйл. Иргэний нисэхийн хяналтын байцаагч, түүний бүрэн эрх***

12.1. Иргэний нисэхийн хяналтын байцаагчаар томилогдох этгээд мэргэшил, ур чадварын хувьд өөрийн шалгах, хяналт тавих этгээдтэй ижил, эсхүл түүнээс дээш түвшний шалгуурыг хангасан байна.

12.2. Иргэний нисэхийн хяналтын байцаагч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 12.2.1. үзлэг шалгалт хийх зорилгоор аль ч үед агаарын хөлөгт саадгүй нэвтрэх;
- 12.2.2. иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн нислэгийн үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламж, объектод аль ч үед саадгүй нэвтрэх;
- 12.2.3. хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох иргэн, хуулийн этгээдээс шаардан гаргуулж авах;
- 12.2.4. Даргаас гэрээгээр шилжүүлсэн бусад бүрэн эрх.

12.2. Иргэний нисэхийн хяналтын байцаагч энэ хууль, иргэний нисэхийн дүрэм, улсын ерөнхий байцаагчийн баталсан зааврын хүрээнд хяналтын үйл ажиллагаа явуулна.

12.3. Иргэний нисэхийн хяналтын байцаагч өөрийн гаргасан аливаа шийдвэрийг Даргад тухай бүр мэдээлж байна.

12.4. Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн дүгнэлтэд аливаа албан тушаалтан хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

12.5. Иргэний нисэхийн хяналтын байцаагч нислэгийн аюулгүй байдлын талаар өөрийн гаргасан шийдвэрийн үнэн зөвийг хариуцна.

12.6. Иргэний нисэхийн хяналтын байцаагч нь хяналт шалгалтын явцад олсон мэдээллийн нууцыг хадгалах үүрэг хүлээнэ.

### **13 дугаар зүйл. Иргэний нисэхийн хяналтын байцаагч болон бусад этгээдэд эрх шилжүүлэх**

13.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ хуулийн 11.1.8, 11.1.9, 11.1.10-д заасан эрхээ иргэний нисэхийн хяналтын байцаагч, бусад этгээдэд гэрээгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болох бөгөөд тухайн шилжүүлсэн эрхийн хязгаарлалт, хугацааг гэрээнд тодорхой заана.

13.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхээ шилжүүлэхгүй.

13.3. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга зохих ёсоор мэргэшсэн иргэнд эрх шилжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсэхгүй байх нөхцөлийг хангасан байна.

13.4. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн ажилтан, шүхэрчин, шүхрийн техникчийн гэрчилгээ олгох эрхийг нисэх клубт */нисэх хамтлагт/* шилжүүлж болно.

13.5. Энэ хуулийн 11.1.9, 11.1.10-т заасан эрхийг шилжүүлж авсан этгээд өөрийн гаргасан шийдвэрийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Даргад нэн даруй тайлагнана.

13.6. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ хуулийн 13.1-д заасны дагуу эрхээ шилжүүлсэн нь түүнийг нислэгийн аюулгүй байдлын талаар хүлээх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.

### ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРМИЙН ЗОХИЦУУЛАЛТ

#### **14 дүгээр зүйл. Иргэний нисэхийн дүрэм**

14.1. Иргэний нисэхийн үйл ажиллагааг энэ хуульд нийцүүлэн зохицуулахдаа иргэний нисэхийн дүрмийг баримтална.

14.2. Иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбоотой дараахь харилцааг дүрмээр зохицуулна:

- 14.2.1. иргэний нисэхийн дүрэмд хэрэглэх нэр томъёоны тодорхойлолт, товчлол;
- 14.2.2. осол, тохиолдлыг мэдээлэх;
- 14.2.3. зөрчлийг шийдвэрлэх болон албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 14.2.4. агаарын хөлөг, бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт, агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадварын удирдамж болон нэмэлт шаардлага, техник үйлчилгээ;
- 14.2.5. аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;
- 14.2.6. нисэхийн ажилтны үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ;
- 14.2.7. агаарын зайг тогтоох, ангилах болон нислэг үйлдэх агаарын зайн зохицуулалт;
- 14.2.8. нислэгийн хөдөлгөөн, нисэхийн холбоо, навигаци, ажиглалт, хэрэглэлийн нислэгийн журам зохиох, нисэхийн цаг уурын болон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 14.2.9. нислэгийн үйл ажиллагааны ерөнхий дүрэм, хэрэглэлийн нислэгийн журам;
- 14.2.10. жиро-глайдер, парасэйл болон хүнгүй агаарын хөлгийн үйл ажиллагаа, хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт;
- 14.2.11. хэт хөнгөн агаарын хөлөг, глайдер, ханг-глайдер болон шүхрийн үйл ажиллагаа, нисэх клубийн */нисэх хамтлагийн/* гэрчилгээжүүлэлт;
- 14.2.12. агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт, жижиг, дунд, том агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа болон гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт;
- 14.2.13. нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт болон агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр;
- 14.2.14. нисдэг тэрэгний дүүжинт тээврийн, хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа, чөлөөт нисэхийн үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт;
- 14.2.15. агаарын хөлөг зохион бүтээх, үйлдвэрлэх болон техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 14.2.16. нисэхийн болон инженер техникийн ажилтны сургалтын байгууллагын гэрчилгээжүүлэлт;
- 14.2.17. агаарын хөлгөөр аюултай бараа тээвэрлэх;
- 14.2.18. аэродром байгуулах болон аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт;
- 14.2.19. үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээжүүлэлтийн үйл ажиллагааны хураамж;
- 14.2.20. иргэний нисэхийн дүрмээр зохицуулах шаардлагатай бусад үйл ажиллагаа.

14.3. Иргэний нисэхийн дүрэм нь олон улсын иргэний нисэхийн баримт бичгийг хэрэглэх, ашиглахад хялбар байх зорилгоор ижил бүтэц, дугаарлалттай байна.

## **15 дугаар зүйл. Дүрмийн шаардлагыг өөрөөр хэрэгжүүлэх**

15.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга иргэний нисэхийн дүрмээр хориглоогүй бол, дараах тохиолдолд агаарын хөлөг, нисэхийн бүтээгдэхүүн, аэродром, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч болон иргэний нисэхийн ажилтныг иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэхийг зөвшөөрч болно:

15.1.1. хүсэлт гаргагч дүрмийн тухайн шаардлагыг хүлээн зөвшөөрч болохуйц өөр хэлбэрээр хангасан бол;

15.1.2. хүсэлт гаргагчийн хэрэгжүүлэхээр санал болгосон арга хэмжээ нь дүрмийн тухайн шаардлагыг хэрэгжүүлснээс илүү үр дүнтэй байвал;

15.1.3. дүрмийн тухайн шаардлагаас чөлөөлснөөр нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй болох нь тогтоогдсон бол.

15.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ зүйлийн 15.1-д заасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй.

## **16 дугаар зүйл. Иргэний нисэхэд гадаад хэл хэрэглэх**

16.1. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд ашиглах техник, технологийн баримт бичиг, үйл ажиллагааны заавар, иргэний нисэхийн дүрмийн тайлбар болон маягтыг англи, орос хэл дээр хэрэглэж болно.

16.2. Агаарын хөлөг, нислэгийн хөдөлгөөний удирдагч хоорондын газар-агаар радио холбоонд англи, монгол хэл ашиглах ба онцгой тохиолдолд харилцан бүрэн ойлголцох өөр хэл ашиглаж болно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **17 дугаар зүйл. Агаарын хөлгийн бүртгэл**

17.1. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг Монгол Улсын агаарын хөлөг гэж тооцно.

17.2. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа, бусад улсад бүртгэгдээгүй агаарын хөлгийг иргэний нисэхийн дүрмийн дагуу Монгол Улсад бүртгүүлнэ.

17.3. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь агаарын хөлгийн үндэсний харьяаллыг тодорхойлох бүртгэлийн нэгдсэн тогтолцоотой байна.

17.4. Монгол Улсад, эсхүл гадаад улсад бүртгэлгүй агаарын хөлгөөр Монгол Улсад нислэг үйлдэхийг хориглоно.

17.5. Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ нь тухайн агаарын хөлгийн үндэсний харьяаллыг гэрчлэх бөгөөд агаарын хөлгийн өмчлөлийг нотлохгүй.

## **18 дугаар зүйл. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар**

18.1. Гадаад улсад үйлдвэрлэгдсэн агаарын хөлгийн маягийг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүлээн зөвшөөрсөн тохиолдолд Монгол Улсад нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж болно.

18.2. Агаарын хөлгийн үйлдвэрлэгч улсын нислэгт тэнцэх чадварын стандартыг Монгол Улсад хүлээн зөвшөөрсөн тохиолдолд уг стандартын дагуу гэрчилгээжсэн агаарын хөлгийн маягийг шууд хүлээн зөвшөөрч болно.

18.3. Агаарын хөлгийн нэмэлт маягийн гэрчилгээг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Даргын зөвшөөрөлтэй хэрэглэнэ.

18.4. Агаарын хөлгийн маягийн гэрчилгээний болон аюулгүй байдлын нөхцөл, шаардлагад нийцэж байгаа нь үзлэг шалгалтаар тогтоогдсон агаарын хөлөгт нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгоно.

18.5. Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн ашиглалтын хэлбэр болон аюулгүй байдлыг хангахад шаардагдах ангилал, хязгаарлалт болон бусад мэдээллийг тусгана.

18.6. Агаарын хөлөгт гарал үүсэл, эзэмшлийн түүх нь тодорхойгүй, үйлдвэрлэгчийн техникийн нөхцөлд нийцээгүй хөдөлгүүр, сэнс, хэрэгсэл болон бусад эд ангийг байрлуулан ашиглахыг хориглоно.

18.7. Хэт хөнгөн агаарын хөлөг, агаарын бөмбөлөг, агаарын хөлгийн загвар болон алсын удирдлагатай нисэх төхөөрөмжөөс бусад агаарын хөлөг хүчин төгөлдөр нислэгт тэнцэх чадварын гэрчилгээгүйгээр нислэг үйлдэхийг хориглоно.

## **19 дүгээр зүйл. Агаарын тээвэрлэгчийн болон нислэгийн операторын /нислэг эрхлэгч/ гэрчилгээ**

19.1. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ хууль болон холбогдох иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан агаарын хөлгөөр арилжааны болон тусгай зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдэд иргэний агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл нислэгийн операторын **/нислэг эрхлэгч/** гэрчилгээ олгоно.

19.2. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга энэ хууль болон холбогдох иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан гадаад улсын хуулийн этгээдэд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл нислэгийн операторын **/нислэг эрхлэгч/** гэрчилгээ олгоно.

19.3. Агаарын тээвэрлэгчийн болон нислэгийн операторын **/нислэг эрхлэгч/** гэрчилгээ нь эрх бүхий этгээд хүчингүй болгох, түдгэлзүүлэх хүртэл хүчинтэй байна.

19.4. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга нь шинээр үүсгэн байгуулагдаж буй хуулийн этгээдэд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг тусгай нөхцөлтэйгөөр, түр хугацаагаар олгож болно.

19.5. Энэ зүйлийн 19.1 болон 19.2-т заасны дагуу олгосон гэрчилгээг бусдад шилжүүлэхийг хориглоно.

## **20 дугаар зүйл. Нисгэгчийн үнэмлэх**

20.1. Монгол Улсад нислэгийн үүрэг гүйцэтгэж буй нисгэгч нь хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэхтэй байна.

20.2. Нисгэгчийн үнэмлэхэд тавигдах шаардлагыг иргэний нисэхийн дүрмээр тогтооно.

20.3. Агаарын тээврийн болон арилжааны нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхгүй нисгэгчийг агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож, нислэг үйлдэхийг хориглоно.

20.4. Гадаад улсын иргэний нисэхийн байгууллагаас олгосон нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нь Монгол Улсад нислэгийн үйл ажиллагаанд оролцох тохиолдолд Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга тухайн үнэмлэхийг хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх, хориглох, эсхүл тодорхой хязгаарлалт тавих шийдвэр гаргана.

## **21 дүгээр зүйл. Нислэгийн ажилтанд тавигдах шаардлага**

21.1. Нислэгийн ажилтан дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

21.1.1. Иргэний нисэхэд хүлээн зөвшөөрөгдөх хөтөлбөр бүхий сургалтын байгууллагад хамрагдсан хүчин төгөлдөр гэрчилгээтэй байх;

21.1.2. Эрүүл мэнд, сэтгэл зүйн үзлэг хяналтад иргэний нисэхийн дүрэмд заасан хугацаанд хамрагдаж тэнцсэн байх;

21.1.3. Иргэний нисэхэд хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын байгууллагад цаг улирлын, хуваарьт сургалтад тогтмол хамрагдсан байх;

21.2. Нислэгийн ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн хувцас, тоноглолоор хангагдана.

## **22 дугаар зүйл. Сургалт**

22.1. үнэмлэх, гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь үйлдвэрлэгчийн, эсхүл энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллагад, эсхүл Даргын хүлээн зөвшөөрсөн, Хэлэлцэн тохирогч улсын нисэхийн сургалтын байгууллагад сурч, мэргэшсэн байна.

22.2. Монгол Улсад иргэний нисэхийн мэргэжлийн сургалт зохион байгуулах байгууллага нь иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна.

22.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн хяналтын байцаагч, ажилтнуудын сургалтын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор сургалтын байгууллагатай байж болно.

## **23 дугаар зүйл. Агаарын хөлгийн техник үйлчилгээ**

23.1. Агаарын тээвэрлэгчийн ашиглаж буй агаарын хөлгийн техник үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн техник үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.

23.2. Монгол Улсын бүртгэлтэй, эсхүл бүртгэгч улсаас гэрээгээр эрх нь шилжигдсэн агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн техник үйлчилгээг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн, эсхүл Даргын хүлээн

зөвшөөрсөн, Хэлэлцэн тохирогч улсын агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.

23.3. Техник үйлчилгээний байгууллага нь тухайн гэрчилгээнд заасан техник үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай бүтэц, инженер, техникийн ажилтан болон тоног төхөөрөмжтэй байна.

#### **24 дүгээр зүйл. Агаарын хөлгийн даргын эрх, үүрэг**

24.1 нислэгийг цаашид дүрэм, зааврын дагуу хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон онцгой нөхцөлд агаарын хөлгийн дарга хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах зорилгоор энэ хууль болон иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргах эрхтэй.

24.2. Агаарын хөлгийн дарга энэ хуулийн 23.1-д заасан онцгой нөхцөлийн үед иргэний нисэхийн дүрэмд зааснаас өөр шийдвэр гаргасан бол энэ тухай агаарын навигацийн үйлчилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

24.3. Агаарын хөлгийн дарга нь нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй үйлдэл гаргасан зорчигчийн үйлдлийг таслан зогсоход чиглэсэн арга хэмжээ авах, тийм арга хэмжээ авахыг багийн бусад гишүүдээс шаардах эрхтэй.

24.4. Агаарын хөлгийн дарга гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэж байх үедээ албадан саатуулагдах нөхцөл байдалд орсон тохиолдолд тухайн улсын эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг дагаж мөрдөх үүрэгтэй.

#### **25 дугаар зүйл. Хувийн нислэг болон нисэх клубын /нислэгийн хамтлагийн/ нислэгийн зардал хуваах**

25.1. Хувийн хэрэгцээнд үйлдэгдэх нислэгийн шууд зардлыг зорчигчтой хуваан гаргуулж болох ба агаарын хөлгийн нисгэгч, эсхүл эзэмшигч уг зардлын 50-иас доошгүй хувийг хариуцна.

25.2. Нисэх клубын /нисэх хамтлагийн/ үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн хувьд танилцах болон хэт хөнгөн агаарын хөлгийн сургалтын нислэгийн шууд зардлыг клубын /нисэх хамтлагийн/ гишүүн, клубын /нисэх хамтлагийн/ үйл ажиллагаатай танилцах хүсэлтэй этгээдээс гаргуулж болно.

#### **26 дугаар зүйл. Гэрчилгээний шаардлагад нийцэх**

26.1. Агаарын хөлгийн үйл ажиллагаа нь иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон гэрчилгээний шаардлагад нийцсэн байхыг дараахь этгээд хариуцна:

26.1.1. хувийн агаарын хөлгийн хувьд тухайн агаарын хөлгийн эзэмшигч, ашиглагч, нисгэгч;

26.1.2. хуулийн этгээдийн эзэмшлийн агаарын хөлгийн хувьд тухайн агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд.

26.2. Агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч нь гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгалд даатгуулсан байна.

## **ТАВДУГААР БҮЛЭГ.**

### **ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

#### ***27 дугаар зүйл. Эдийн засгийн зохицуулалт***

27.1. Иргэний нисэхийн эдийн засгийн зохицуулалтыг дараахь зорилгоор хэрэгжүүлнэ. Үүнд:

- 27.1.1. иргэний нисэхийн үйлчилгээний эдийн засгийн үр ашигтай орчин бүрдүүлэх;
- 27.1.2. иргэний нисэхийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;
- 27.1.3. иргэний нисэхийн үйлчилгээнд нислэгийн аюулгүй байдалд зарцуулах санхүүгийн боломжтой байх нөхцөлийг бүрдүүлэх;
- 27.1.4. иргэний нисэхийн үйлчилгээнд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх,
- 27.1.5. хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах.

#### ***28 дугаар зүйл. Эдийн засгийн зохицуулалтын дүрэм***

28.1. Эдийн засгийн зохицуулалтын дүрмээр дараахь харилцааг зохицуулна:

- 28.1.1. Олон улсын хуваарьт нислэгийн агаарын тээвэрлэгчид нислэгийн шугамын эрх олгох;
- 28.1.2. Гадаадын агаарын тээвэрлэгчид зөвшөөрөл олгох;
- 28.1.3. Агаарын тээвэрлэгчийн хариуцлага;
- 28.1.4. Агаарын хөлгийн түрээсийн бүртгэл, зохицуулалт;
- 28.1.5. Тээвэрлэлтийн гэрээ;
- 28.1.6. Тээвэрлэлтийн үнэ, тариф;
- 28.1.7. Шуудан тээвэрлэх;
- 28.1.8. Зорчигчийн бүртгэл;
- 28.1.9. зайлшгүй үйлчилгээний нислэгт татаас олгох;
- 28.1.10. Агаарын навигацийн үйлчилгээний хураамж;
- 28.1.11. Нийтийн зориулалтаар ашиглах нисэх буудал, аэродромын үйлчилгээний хураамж;
- 28.1.12. Нисэхийн хамгаалалтын үйлчилгээний хураамж;
- 28.1.13. Статистикийн мэдээлэл;
- 28.1.14. ашгийн төлөө агаарын тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудал;
- 28.1.15. Иргэний нисэхийн салбарын ажилчдын нийгмийн хамгаалал болон сургалтын асуудал.

28.2. Эдийн засгийн дүрмийн шаардлагыг өөрөөр хэрэгжүүлэх зөвшөөрөл нь ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бусад этгээдэд нэгэн адил үйлчлэх бөгөөд аль нэг этгээдэд тусгайлсан хөнгөлөлт, давуу байдал олгохгүй.

#### ***29 дүгээр зүйл. Агаарын тээвэрлэлтийн зөвшөөрөл***

29.1. Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд, гадаадын агаарын тээвэрлэгчид олон улсын агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

29.2 Ачаа тээврийн дагнасан нислэг болон орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхэд агаарын тээвэрлэлтийн зөвшөөрөл шаардахгүй.



29.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ зүйлийн 28.1-д заасны дагуу олгосон зөвшөөрлийг үндэслэлгүйгээр түдгэлзүүлж, эсхүл хүчингүй болгож хөрөнгө оруулагчийг эрсдэлд оруулахгүй байх үүрэгтэй.

29.4. Агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй.

### **29 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн хариуцлага**

30.1. Агаарын тээвэрлэгч нь зорчигч, агаараар ачаа илгээгч болон ачаа хүлээн авагчийн өмнө аюулгүй, сааталгүй тээвэрлэлтийн хариуцлага хүлээнэ.

30.2. Олон улсын нислэгт оролцож байгаа агаарын тээвэрлэгчийн хариуцлагын хязгаарыг Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулна.

30.3. Орон нутгийн агаарын тээврийн үйл ажиллагаанд агаарын тээвэрлэгчийн хариуцлагын хязгаар дараахь хэмжээтэй байна:

30.3.1. нислэгийн үед гарсан осол болон нислэгийн үед тохиолдсон гэнэтийн үйл явдлын улмаас зорчигчийн амь насны хохиролд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 300 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх;

30.3.2. нислэгийн үед гарсан осол болон нислэгийн үед тохиолдсон гэнэтийн үйл явдлын улмаас биед гэмтэл учирч, хөдөлмөрийн чадварыг их, бага хэмжээгээр алдсан тохиолдолд шүүх эмнэлгийн дүгнэлтэд үндэслэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх;

30.3.3. нислэгийн үед ачаа тээш алдагдсан, цаашид ашиглах боломжгүйгээр гэмтсэн тохиолдолд тухайн агаарын тээвэрлэгчийн журамд зааснаар хохирлыг барагдуулна.

30.4. Агаарын хөлгийн ослын улмаас зорчигч нас барсан, эсхүл хүнд гэмтсэн тохиолдолд агаарын тээвэрлэгч энэ хуулийн 29.3-д заасны дагуу нөхөн олговор олгох бөгөөд 29.3.1-д заасан хариуцлагын хязгаарын 15 хувиас багагүй хэмжээний нөхөн олговрыг тухайн ослын хохирогчийг нас барсныг таньж тогтоосноос хойш 15 хоногийн дотор үл маргах журмаар урьдчилан төлөх үүрэгтэй.

30.5. Тээвэрлэгч нь агаарын хөлгөөр зорчигчийн амь нас, эрүүл мэнд болон гуравдагч этгээдэд учруулсан хохирол, түүнчлэн зорчигчийн тээш, ачаа, шуудан алдагдах, гэмтсэн тохиолдолд нөхөн төлбөр олгох хариуцлагын даатгалд даатгуулна.

30.6. Тээвэрлэгч нь агаарын хөлгийн багийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд учирч болох хохирлыг даатгуулах үүрэгтэй. Агаарын хөлгийн багийн гишүүдэд олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь зорчигчийн өмнө хүлээх хариуцлагын хэмжээнээс багагүй байна.

### **31 дүгээр зүйл. Агаарын тээвэр дэх өрсөлдөөн**

31.1. Нийгмийн зайлшгүй үйлчилгээнд татаас олгож байгаагаас бусад тохиолдолд дотоодын агаарын тээвэрлэлтийн үнэ тарифыг төрөөс зохицуулахгүй.

31.2. Нэг нислэгийн шугамд үйлчилж байгаа агаарын тээвэрлэгчид ижил нөхцөлтэй үйлчилгээнд ижил үнэ тогтоохыг хориглоно.

31.3. Агаарын тээврийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай сум, суурин газарт хүргэх нийгмийн зайлшгүй үйлчилгээ, Засгийн газрын бодлого, дэмжлэгээр шинээр

нислэгийн шугам нээж байгаагаас бусад нислэгийн шугамд өрсөлдөөнийг хязгаарлахгүй.

31.4. Агаарын тээвэрлэгч нь өөрийн эзэмшлийн техник үйлчилгээ, сургалт, газрын үйлчилгээ, шатахуун хангалтын үйлчилгээг уг үйлчилгээ шаардлагатай өрсөлдөгчдөө үзүүлэхээс хүндэтгэх шалтгаангүйгээр татгалзах, тус үйлчилгээг зах зээлийн үнэлгээнээс өндөр үнэлэн үйлчилж, өрсөлдөгчийнхөө зардлыг нэмэгдүүлэхийг хориглоно.

31.5. Агаарын тээвэрлэгч нь өөрийн өрсөлдөгч, түүний бүтээгдхүүнийг нэр зааж харьцуулсан зар сурталчилгаа явуулахыг хориглоно.

### **32 дугаар зүйл. Агаарын тээвэрлэгчийн өмчлөл болон ажиллах хүч**

32.1. Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн өмчлөлийн 51-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн, эсхүл хуулийн этгээдийн өмчлөлд байна.

32.2. Агаарын тээвэрлэгч нь өөрийн өмчлөлийн эрхийн талаархи аливаа өөрчлөлтийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд мэдэгдэх үүрэгтэй.

32.3. Агаарын тээвэрлэгчийн нислэгийн ажилтнуудын 90-ээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байна.

32.4. Агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаанд оролцогч ажилтны 75-аас доошгүй хувь нь агаарын тээвэрлэгчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсан байнгын ажилтан байна.

32.5. Контрактаар ажиллах ажилтны ажиллах хугацаа нь тухайн этгээдийн мэргэжлийн үнэмлэхний Монгол Улсад зөвшөөрөгдсөн хугацаагаар хязгаарлагдана.

32.6. Нислэгийн аюулгүй байдал болон зорчигчийн эрх ашгийг хохироосон үйлдлийн улмаас эрүүгийн хариуцлага хүлээсэн этгээд агаарын тээвэрлэгчийн удирдлагад ажиллахыг хориглоно.

### **33 дугаар зүйл. Гадаадын агаарын тээвэрлэгчид зөвшөөрөл олгох**

33.1. Гадаад улсаас, Монгол Улсын хооронд хуваарьт нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх гадаадын агаарын тээвэрлэгч нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс зөвшөөрөл авна.

33.2. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь шаардлагыг хангасан гэж үзвэл гадаадын агаарын тээвэрлэгчид зөвшөөрөл олгож болно:

33.2.1. хүсэлт гаргагч нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн шаардлагыг хангасан, агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу томилогдож, хэлэлцээрийн зохих шаардлагыг хангасан байх;

33.2.2. тухайн зөвшөөрлийг олгох нь Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн хууль ёсны ашиг сонирхолд харшлахгүй байх.

33.3. Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хууль болон иргэний нисэхийн дүрэм, аюулгүй байдлын, эсхүл тухайн зөвшөөрлийн нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд уг зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох эрхтэй.

33.4. Гадаадын агаарын тээвэрлэгчийг Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор нэг цэгээс, нөгөө цэгийн хооронд агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ.**

### **АГААРЫН НАВИГАЦИЙН ҮЙЛЧИЛГЭЭ**

#### ***34 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага***

34.1. Монгол Улсын агаарын зайд агаарын навигацийн үйлчилгээг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн төрийн өмчит агаарын навигацийн үйлчилгээний байгууллага үзүүлнэ.

34.2. Агаарын навигацийн үйлчилгээний зүй ёсны монополь байдал, нислэгийн аюулгүй байдлыг хангуулах, мэргэжлийн бодлого зохицуулалтыг хангах үүднээс Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяанд байна.

34.3. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын санхүүжилт нь агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлого болон үйл ажиллагааны бусад орлогоос бүрдэнэ.

34.4 Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын агаарын навигацийн үйлчилгээнд ашиглах нисэхийн, газрын гадаргуугийн, саадын болон аэродромын зургийг агуулсан нисэхийн өгөгдлийн нэгдмэл санг бүрдүүлэх үүрэгтэй.

#### ***35 дугаар зүйл. Агаарын навигацийн үйлчилгээ***

35.1. Агаарын навигацийн үйлчилгээнд ашиглах холбооны давтамж нь хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалагдсан байна.

35.2. Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд зориулсан холбоо цахилгаан ашиглалтгүй болсон тохиолдолд нислэгийн аюулгүй байдлыг хангах, нислэгийн хөдөлгөөн удирдах хойшлуулшгүй ажиллагаатай холбоотой мэдээллийг нийтийн холбооны бүх төрлийн хэрэгслээр тэргүүн ээлжинд саадгүй дамжуулна.

35.3. Агаарын хөлгийн аэродромын бүсийн ойртолт, буулт хөөрөлтийн нислэгийн хөдөлгөөнд ашиглагдах агаарын навигацийн тоног төхөөрөмж нь аэродром эзэмшигчийн өмчлөлд байж болно.

35.4. Монгол Улсын иргэний нисэхийн зориулалтаар ашиглаж буй агаарын зай болон агаарын замд буудлага, дэлбэлэлт хийх, пуужин харвах зэргээр нислэгт аюул учруулж болзошгүй үйл ажиллагаа явуулахад навигацийн үйлчилгээний байгууллагаас зөвшөөрөл авна.

35.5. Агаарын хөлөг нислэг үйлдэж байгаа үед тухайн агаарын хөлөгт агаарын навигацийн үйлчилгээ үзүүлж байгаа агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тоног төхөөрөмжийн ажиллагааг зориудаар зогсоохыг хориглоно.

### **36 дугаар зүйл. Агаарын зайд нислэг үйлдэх зөвшөөрөл**

36.1. Гадаадын иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийн нислэгтэй холбоотой мэдээллийг агаарын навигацийн үйлчилгээний байгууллагад урьдчилан мэдэгдэж, нислэг үйлдэх зөвшөөрөл авна.

36.2. Агаарын хөлөг нь Монгол Улсын агаарын зайд орох, гарахдаа агаарын навигацийн үйлчилгээний байгууллагаас агаарын хил нэвтрэх зөвшөөрөл авна.

### **37 дугаар зүйл. Зөрчил гаргасан агаарын хөлөг**

37.1. Дараахь агаарын хөлгийг зөрчил гаргасан агаарын хөлөг гэж үзнэ.

37.1.1. бодит ажиглалтын төхөөрөмж ашиглан зөв таньж тогтоогдоогүй байдалтай Монгол Улсын агаарын зайд нэвтэрсэн;

37.1.2. Монгол Улсын агаарын зайд эрх бүхий байгууллагын зохих зөвшөрөлгүй нэвтэрсэн;

37.1.3. зөвшөөрөлд зааснаас өөр цэгээр нэвтэрсэн;

37.1.4. цэргийн үйл ажиллагааны болон хязгаарлалттай бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрсэн;

37.1.5. нислэг үйлдэж буй бусад агаарын хөлөгт аюул учруулж болзошгүй үйлдэл гаргасан;

37.1.6. нислэгийн төлөвлөгөөнд тусгагдсан, эсхүл агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын зөвшөөрсөн зам, өндөр, хурдыг хүндэтгэх шалгаангүйгээр өөрчилсөн;

37.2. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь зөрчил гаргасан агаарын хөлгийн талаар Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагад мэдэгдэж, агаарын хөлгийн нисэх багт зөрчлөө нэн даруй зогсоох, эсхүл заасан газарт буух шаардлага тавина.

37.3. Зөрчил гаргасан агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний удирдлагыг Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага хариуцна.

### **38 дугаар зүйл. Агаарын хөлөгт тусламж үзүүлэх**

38.1. Агаарын навигацийн үйлчилгээний байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аюул тулгарсан агаарын хөлгийн талаар зохих журмын дагуу холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

38.2. Аюул тулгарсан агаарын хөлгийг ойролцоог нисэх буудалд буулгахад боломжит арга хэмжээг агаарын навигацийн үйлчилгээний байгууллага авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

38.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт аюул тулгарсан, эсхүл осолдсон агаарын хөлөгт тусламж үзүүлэх, эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

38.4. Орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд осолдсон агаарын хөлгийн талаар холбогдох байгууллагад нэн даруй мэдээлэх, хүмүүсийн амь насыг аврах, эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалах үүрэгтэй.

### **39 дүгээр зүйл. Аюулын дохио**

39.1. Аюул тулгарсан, эсхүл осолдсон агаарын хөлөгт тусламж үзүүлэхэд эрэн хайх, авран туслах үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аюулын дохиог ашиглана.

39.2. Хүлээн зөвшөөрөгдсөн давтамж, аюулын дохиог хүлээн авсан ажилтан, хуулийн этгээд нь дүрэмд заасны дагуу яаралтай арга хэмжээг авах үүрэгтэй.

#### **40 дугаар зүйл. Эрэн хайх, авран туслах үйл ажиллагаа**

40.1. Аюул тулгарсан, эсхүл осолдсон агаарын хөлгийн тухай мэдээлэл нь тэргүүн ангилалд байна.

40.2. Аюул тулгарсан, эсхүл осолдсон агаарын хөлгийн талаар мэдээлэл авсан онцгой байдлын холбогдох байгууллага нь эрэн хайх, авран туслах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулна.

40.3. Сураггүй алга болсон агаарын хөлгийг эрэн хайх ажиллагааг зогсоох шийдвэрийг Засгийн газар гаргана.

#### **41 дүгээр зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний хураамж**

41.1. Агаарын навигацийн үйлчилгээний хураамж, түүний төрөл, хэмжээг эдийн засгийн зохицуулалтын дүрмийн дагуу иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

41.2. Агаарын навигацийн үйлчилгээ нь ашгийн төлөө бус байна.

41.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт буулгүйгээр дамжин өнгөрөх нислэгт үзүүлсэн агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогын зохих хэсгийг нислэгийн аюулгүй байдлыг хангах, нисэх буудал, аэродромын болон нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

#### **42 дугаар зүйл. Агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн хөнгөлөлт**

42.1. Дараахь тохиолдолд агаарын навигацийн үйлчилгээний хураамжаас чөлөөлнө:

42.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт нислэг үйлдэх, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин 3300 килограммаас ихгүй бол;

42.1.2. төлбөртэй ачаалалгүйгээр үйлдэж байгаа сургалт, дадлагын нислэг;

42.1.3. түргэн тусламжийн нислэг;

42.1.4. гамшиг, ослын үеийн нислэг;

42.1.5. Засгийн газар, олон улсын байгууллагын хүсэлтээр үйлдэж буй хүмүүнлэгийн тусламжийн нислэг;

42.1.6. агаарын навигацийн тоног төхөөрөмжийг тохируулах, шалгах нислэг;

42.1.7. осолдсон агаарын хөлгийг эрэн хайх, авран туслах болон ослын хохирогчдын ар гэрийн хүмүүсийг тээвэрлэх захиалгат нислэг;

42.1.8. эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан тохиолдолд онцгой үүргийн нислэг;

42.1.9. батлан хамгаалах болон хил хамгаалах чиг үүргийн дагуу хийгдэх нислэг.

42.2. Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн нислэгт нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ үзүүлэхдээ хялбаршуулсан журам ашиглаж болно.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ.**

### **НИСЭХ БУУДАЛ, АЭРОДРОМЫН ҮЙЛЧИЛГЭЭ**

#### ***43 дугаар зүйл. Нисэх буудал, аэродром***

43.1. Суудлын багтаамж нь 30, түүнээс дээш тооны суудалтай агаарын хөлөгт үйлчлэх олон улсын нислэгийн үйл ажиллагаанд ашигладаг аэродром нь энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн байна.

43.2. Нисэх буудал, аэродромын үйлчилгээ эрхлэгч нь олон улсын иргэний нисэхийн байгууллагын шаардлагын дагуу тухайн аэродромын ангилалыг хангасан тоног төхөөрөмжөөр тоноглож, нислэгийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

43.3. Нутгийн захиргааны байгууллага нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан шаардлагатай тохиолдолд аэродром, ерөнхий зориулалтын нисэхийн зурвас, талбай байгуулах газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авна.

43.4. Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нислэгийн аюулгүй байдлын шаардлагын үүднээс харьяалах хот, аймаг, сумын Засаг даргатай хамтарч аэродром орчмын аюулгүйн бүсийг тогтооно.

43.5. Аэродром орчмын дэвсгэр газарт нислэгийн зориулалттай тэмдэг, гэрэл дохиололтой ижил төрлийн зүйлс байрлуулахыг хориглоно.

43.6. Аэродромын аюулгүйн бүсэд нислэгийн аюулгүй байдалд харшлах үйлдвэрлэл явуулах, үйлчилгээ эрхлэх жагсаалт, барилга, байгууламжийн өндрийн хязгаарлалт тогтоосон журмыг иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

#### ***44 дүгээр зүйл. Нисэх буудал, аэродромын өмчлөл***

44.1. Олон улсын нислэгт үйлчилдэг, эсхүл улсын нисэхтэй хамтран ашигладаг нисэх буудал, аэродром төрийн болон орон нутгийн өмчлөлд байна.

44.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулсан хатуу хучилттай хөөрөх буух зурвас бүхий аэродромын зориулалтыг өөрчлөх, татан буулгахыг хориглоно.

44.3. Нисэх буудал, аэродромыг нийтийн хэрэглээнд ашиглах зөвшөөрлийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно. Энэ зөвшөөрлийг эзэмшигч нисэх буудал нь иргэний агаарын хөлөгт ялгаваргүй үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.

#### **45 дүгээр зүйл. Аэродромын үйл ажиллагааг зогсоохыг хориглох**

45.1. Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд нийтэд үйлчлэхээр бэлэн байдлыг зарласан нисэх буудал, аэродром нь нислэгийн аюулгүй байдлыг хангуулах бодит шаардлагаас бусад тохиолдолд агаарын хөлөгт үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, үйл ажиллагаагаа зогсоохыг хориглоно.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ.**

#### **НИСЭХИЙН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ**

#### **46 дугаар зүйл. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага**

46.1. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээг энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн, нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага үзүүлнэ.

46.2. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

46.3. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь аюулгүйн хамгаалалттай холбоотой хууль, тогтоомжийг зөрчсөн этгээдийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх зорилгоор саатуулах эрхтэй.

#### **47 дугаар зүйл. Аюулгүйн үзлэг**

47.1. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллага нь олон улсын нислэг үйлдэх агаарын хөлөгт нэвтрэн орох аливаа этгээд болон тээвэрлэх ачаа, тээш, шууданд галт зэвсэг, тэсрэх бодис болон агаараар тээвэрлэхийг хориглосон бусад эд зүйлсийг илрүүлэх зорилгоор аюулгүйн үзлэг хийнэ.

47.2. Энэ хуулийн дагуу гүйцэтгэж байгаа аюулгүйн үзлэг хийлгэхээс татгалзсан этгээдийг агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглоно.

#### **48 дугаар зүйл. Нисэх буудал, агаарын навигацийн байгууламжийн хамгаалалт**

48.1. Нисэх буудал болон агаарын навигацийн байгууламж нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын хамгаалалтад байж болно.

48.2. Энэ хуулийн 46.1-д заасан аюулгүйн үзлэг, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ шаардлагатай нисэх буудал болон нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ шаардлагатай агаарын навигацийн байгууламжийн жагсаалтыг Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга батална.

#### **49 дүгээр зүйл. Агаарын хөлгийн нисэх багийн бүхээгийн халдашгүй байдал**

49.1. Нислэгийн үед агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт агаарын хөлгийн даргын зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг хориглоно.

49.2. Зорчигч тээврийн нислэгийн үед тийрэлтэт агаарын хөлгийн нисэх багийн бүхээгт нэг нисгэгч ганцаар үлдэхийг хориглоно.

## **50 дугаар зүйл. Хэв журам зөрчсөн зорчигч**

50.1. Багийн гишүүн нь нислэгийн үед аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болох үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээ авч болно. Энэ арга хэмжээ нь аюул учруулагч этгээдийн үүсгэж байгаа заналхийлэл, аюулын түвшинтэй дүйцэхүйц байх бөгөөд нислэгийн аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй байна.

50.2. Багийн гишүүн нь нислэгийн үед сөргөөр нөлөөлж болох үйлдэл гаргасан, гаргахыг завдсан зорчигчийг аюулгүй болгох арга хэмжээ авахдаа шаардлагатай тохиолдолд зорчигчийн тусламж авч болно.

50.3. Энэ хуулийн 50.1, 50.2-т заасан хэв журам зөрчсөн зорчигчийн үйлдлийг аюулгүй болгох арга хэмжээний журмыг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ.**

### **АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ТОХИОЛДЛЫГ ШИНЖЛЭН ШАЛГАХ**

#### **51 дүгээр зүйл. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба**

51.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, тохиолдлыг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба гүйцэтгэнэ.

51.2. Агаарын хөлгийн осол, тохиолдлыг шинжлэн шалгах ажиллагааны үндсэн зорилго нь осол, тохиолдлоос сэргийлэхэд чиглэгдэх бөгөөд гэм буруутныг тогтоох, хариуцлага хүлээлгэх зорилгогүй байна.

51.3. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд байх бөгөөд шинжлэн шалгах үйл ажиллагаа нь хараат бус, бие даасан байна.

51.4. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь энэ хуулиар олгогдсон эрхийн хүрээнд шинжлэн шалгах ажиллагааг явуулахад хүрэлцэх хэмжээний төсөвтэй байна. Төсөв нь агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн орлогоос бүрдэнэ.

51.5. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг тус улсын нутаг дэвсгэрийн гадна осол, ноцтой тохиолдолд өртсөн үед шинжлэн шалгах ажиллагаанд олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын нэрийн өмнөөс Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцоно.

51.6. Хууль хяналтын байгууллага нь хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд агаарын хөлгийн осол, тохиолдлыг энэ хуульд зааснаас өөр зорилгоор шалгах ажиллагааг энэ хуулийн 51.1 дахь заалт хязгаарлахгүй.

51.7. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь осол, тохиолдолтой холбоотой мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийж осол, тохиолдлын шалтгаан болон нөлөөлсөн хүчин зүйлийг тогтоон, шинжлэн шалгах ажиллагааны тайлан гаргана.



51.8. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь шаардлагатай гэж үзвэл шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд, мөн шинжлэн шалгах ажиллагааны тайланг үндэслэн аюулгүй байдлын зөвлөмж гаргана.

51.9. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны ажилтныг осолтой холбоотойгоор хэрэг мөрдөн шалгах болон хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцуулахыг хориглоно.

51.10. Агаарын хөлгийн осол, тохиолдлыг шинжлэн шалгах баг нь осол, тохиолдлын газарт ажиллахад шаардагдах хамгаалах хувцас хэрэгсэл, шаардлагатай тоног төхөөрөмж, холбоо, тээврийн хэрэгслээр хангагдсан байна.

## **52 дугаар зүйл. Агаарын хөлгийн осол, тохиолдлыг шинжлэн шалгах**

52.1. Агаарын хөлгийн эзэмшигч, ашиглагч, хөлгийн дарга, нисэх багийн гишүүд, аэродром болон агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын ажилтан нь осол, тохиолдлын мэдээллийг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанд нэн даруй, боломжит хэлбэрээр өгөх үүрэгтэй.

52.2. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь осол, тохиолдлын мэдээллийг хүлээн авмагц шинжлэн шалгах ажиллагааг нэн даруй эхлүүлэх үүрэгтэй.

52.3. Осол, тохиолдолд өртсөн агаарын хөлөгтэй холбоотой баримт, нотолгоог эзэмшигч болон холбогдох бусад этгээд шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл хадгалж хамгаалах үүрэгтэй.

52.4. Агаарын хөлгийн осол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гарсан тохиолдолд иргэн, гамшгаас хамгаалах, цагдаа, хил хамгаалах болон нутгийн захиргааны байгууллага, батлан хамгаалахын анги салбарууд Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны үйл ажиллагаанд шаардлагатай туслалцааг үзүүлэх үүрэгтэй.

## **53 дугаар зүйл. Ерөнхий шинжлэн-шалгагч, түүний бүрэн эрх**

53.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албыг Ерөнхий шинжлэн-шалгагч удирдах бөгөөд Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ажлаа тайлагнана.

53.2. Ерөнхий шинжлэн-шалгагч нь энэ хуулийн 54.1.1.-д заагдсан шаардлагыг хангасан агаарын тээврийн нисгэгч, агаарын хөлгийн инженер болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын мэргэжилтэй шинжлэн шалгагч байна;

53.3. Ерөнхий шинжлэн-шалгагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

53.3.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны ажилтан, шинжлэн-шалгагчийг томилох, чөлөөлөх;

53.3.2. агаарын хөлгийн осол, тохиолдлын шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэх багийн ахлагч болон гишүүдийг томилох;

53.3.3. осол, тохиолдлын шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах;

- 53.3.4. шаардлагатай гэж үзвэл осол, ноцтой тохиолдлыг шинжлэн шалгах ажиллагааг бүхлээр нь эсвхүл хэсэгчлэн Хэлэлцэн тохирогч улсын эрх бүхий байгуулагаар гүйцэтгүүлэхээр эрх шилжүүлэх саналыг гаргах;
- 53.3.4. ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 53.3.5. шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг батлах;
- 53.3.6. агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албаны төсвийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;
- 53.3.7. Шинжлэн шалгах ажиллагаанд мөрдөх заавар, үйл ажиллагааны журмыг батлах.

#### **54 дүгээр зүйл. Шинжлэн-шалгагч, түүний бүрэн эрх**

54.1. Шинжлэн-шалгагч нь дараахь шаардлагыг хангасан байна:

54.1.1. Агаарын тээврийн нисгэгчийн зэрэглэлтэй нисгэгч, агаарын хөлгийн инженер, мэргэжилтэй байна. Мөн шинжлэн шалгагчийн сургалтанд хамрагдсан, нислэгийн үйл ажиллагаа, нислэгийн хөдөлгөөний удирдлагын болон нисэхийн менежментийн чиглэлээр ажилласан дадлага туршлага бүхий боловсон хүчин байж болно.

54.2. Шинжлэн-шалгагч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

54.2.1. албан үүргээ гүйцэтгэхдээ осол, тохиолдолд холбоотой нотлох баримт, барилга байгууламжид аль ч үед саадгүй нэвтрэх;

54.2.2. шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээ, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох иргэн, хуулийн этгээдээс шаардан гаргуулж авах;

54.2.3. Ерөнхий шинжлэн-шалгагчаас олгосон бусад эрх.

#### **55 дугаар зүйл. Шинжлэн шалгах багийн ахлагч, түүний бүрэн эрх**

55.1. Агаарын хөлгийн осол, тохиолдлыг шинжлэн шалгах багийн ахлагч нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

55.1.1. Агаарын хөлгийн шинжлэн шалгах багийн ахлагч нь Ерөнхий шинжээчийг төлөөлөн тухайн шинжлэн шалгах ажиллагааг хуулийн дагуу удирдан зохион байгуулах онцгой эрхтэй

55.1.2. осол, тохиолдол болсон газарт аль ч үед саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, бүх төрлийн эд зүйлст бүрэн хяналтаа тогтоох;

55.1.3. тухайн нислэгтэй холбоотой тоон болон соронзон бичлэгүүд, бусад нотлох баримтыг өөрийн бүрэн хяналтад авах;

55.1.4. шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд

нэвтрэх, эд зүйл үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;

55.1.5. шинжлэн шалгах ажиллагааны явцыг ерөнхий шинжлэн шалгагчид илтгэх, ослын шалтгаан, нөлөөлсөн байж болох хүчин зүйлд тулгуурлан Аюулгүй байдлын зөвлөмж гаргах ажиллагааг зохион байгуулах.

55.1.6. шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилох;

55.1.7. шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төслийг гаргах;

55.1.8. хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

### **56 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааны тайлан**

56.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба, шинжлэн шалгах ажиллагааны эцсийн тайланг гаргахаас өмнө тухайн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай байгууллага, хамтран оролцсон улс болон холбогдох байгууллагуудад санал авах зорилгоор тайлангийн төслийг хүргүүлнэ.

56.2. Нууц мэдээллийг нээлттэй болгох нь шинжлэн шалгах ажиллагаанд ач холбогдолтой болохыг эрх бүхий байгууллага тогтоосноос бусад тохиолдолд, шинжлэн шалгах ажиллагааны тайлангийн төсөл, нотлох баримтыг хууль, тогтоомжид зааснаас өөр зорилгоор зөвшөөрөлгүйгээр задруулах, түгээхийг хориглоно.

56.3. Агаарын хөлгийн осол, тохиолдлыг шинжлэн шалгах ажиллагааны тайланг гэм буруутныг тогтоох, хариуцлага ногдуулахтай холбоотой шүүхийн болон бусад ажиллагаанд нотлох баримтаар ашиглахгүй.

### **57 дугаар зүйл. Аюулгүй байдлын зөвлөмж**

57.1. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь нислэгийн аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй нөхцөл байдлыг арилгах, сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд Аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

57.2. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах алба нь Аюулгүй байдлын зөвлөмжийг, Иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Дарга, холбогдох бусад этгээд болон гадаад улсад хүргүүлэх үүрэгтэй.

57.3. Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд нь зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч, хариу мэдэгдэх үүрэгтэй.

57.4. Энэ хуулийн 57.2-т заасан Аюулгүй байдлын зөвлөмжийг хүлээн авсан этгээд нь тухайн зөвлөмжийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байх бодит үндэслэл байгаа гэж үзвэл тайлбарыг Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах албанд хүргүүлэх үүрэгтэй.

### **58 дугаар зүйл. Шинжлэн шалгах ажиллагааг сэргээх**

58.1. Шинжлэн шалгах ажиллагаа дууссаны дараа тухайн ажиллагааны үр дүнг өөрчилж болох баримт, нөхцөл байдал шинээр илэрсэн тохиолдолд Ерөнхий шинжлэн-шалгагч шинжлэн шалгах ажиллагааг сэргээн дахин хийж болно.

## **59 дүгээр зүйл. Аюулгүй байдлын өгөгдөл болон аюулгүй байдлын мэдээллийг хамгаалах**

59.1. Аюулгүй байдлын өгөгдөл болон аюулгүй байдлын мэдээллийг хамгаалах үйл ажиллагааг Чикагогийн конвенцийн 19 дүгээр Хавсралтад заасны дагуу ойлгож хэрэглэнэ.

59.2. Аюулгүй байдлын өгөгдөл болон аюулгүй байдлын мэдээллийн үндсэн зорилго нь нислэгийн аюулгүй байдлыг сайжруулах болон хадгалахад чиглэгдэх бөгөөд гэм буруутныг тогтоох, хариуцлага хүлээлгэх зорилгогүй байна.

59.3. Аюулгүй байдлын өгөгдөл болон аюулгүй байдлын мэдээллийг цуглуулах, боловсруулах, солилцох, түгээх, хадгалах, хамгаалах үйл ажиллагааг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.

59.4. Аюулгүй байдлын өгөгдөл болон аюулгүй байдлын мэдээллийг нислэгийн аюулгүй байдлыг хадгалах болон сайжруулахаас өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

## **60 дугаар зүйл. Аюулгүй байдлын өгөгдөл болон аюулгүй байдлын мэдээллийг хянан шалгах**

60.1. Аюулгүй байдлын өгөгдөл болон аюулгүй байдлын мэдээллийг олж тогтоох, эсхүл сайн дурын болон заавал илтгэх журмаар хүлээн авсан даруй иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хянан шалгах ажиллагааг эхлүүлнэ.

60.2. Аюулгүй байдлын өгөгдөл болон аюулгүй байдлын мэдээллийг хянан шалгах ажиллагааг гүйцэтгэж, тайлан гарах хүртэл хадгалж хамгаална.

60.3. Аюулгүй байдлын өгөгдөл ба аюулгүй байдлын мэдээллийг хамгаалалтаас гаргах, шилжүүлэх, нийтэд мэдээлэх тухай шийдвэрийг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга гаргана.

60.4. Аюулгүй байдлын өгөгдөл, аюулгүй байдлын мэдээлэл, тэдгээрийн эх үүсвэрийг хамгаалах, нийтэд зарлан мэдээлэх болон ашиглах журмыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **АРАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ**

### **61 дүгээр зүйл. Үнэмлэх, гэрчилгээ, эрх хасах шийдвэр гаргах болон уг шийдвэрт гомдол гаргах**

61.1. Энэ хууль болон иргэний нисэхийн дүрмийг зөрчсөн үйлдэл нь Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээргүй бол Ерөнхий байцаагч, эсхүл иргэний нисэхийн хяналтын байцаагч дараахь арга хэмжээг авна:

61.1.1 үнэмлэх, гэрчилгээ, эрхийг 14 хоногоос 2 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлэх;

61.1.2 үнэмлэх, гэрчилгээ, эрхийг хүчингүй болгох;

61.1.3 энэ хуулийн 61.1.2-т заасан арга хэмжээ авахуулсан этгээдийн үнэмлэх, гэрчилгээ, эрх сэргээх өргөдөл гаргах эрхийг 1 жил хүртэлх хугацаагаар хасах.

61.2. Онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд иргэний нисэхийн хяналтын байцаагч нь үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, өөрчлөх, хүчингүй болгох шийдвэр гаргахын өмнө тухайн гэрчилгээ, эсхүл үнэмлэх эзэмшигчид тайлбар өгөх боломж олгох үүрэгтэй.

61.3. Үнэмлэх, гэрчилгээнд нь үндэслэлгүйгээр өөрчлөлт оруулсан, түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүйд тооцсон шийдвэр гаргасан гэж үзвэл эзэмшигч нь дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

61.4. Энэ хуулийн 61.3-т заасан гомдлыг хүлээн авсан дээд шатны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр гаргагчийн гаргасан шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нягтлан үзэж, шийдвэр гаргагчийн шийдвэрийг хэвээр үлдээх, эсхүл цуцлаж дахин өөр шийдвэр гаргана.

61.5. Энэ хуулийн 61.4-т заасан дээд шатны шийдвэртэй гомдол гаргасан үнэмлэх, зэрэглэл, гэрчилгээ эзэмшигч санал нийлэхгүй байвал шүүхэд гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.

## **ГАРЫН ҮСЭГ**